

Хөгжмийг Д.Лувсаншарав
Цомнолыг Д.Пүрэвдорж

**“Шивээ хиагт”
дуурь**

Бид одоо ямар хөгжим сонсох
вэ?

“Шивээ хиагт”
дуурийн
Онолтын ари

Д.Лувсаншарав

Нэгдүгээр үзэгдэл

Их хүрээ хиагтын замын өртөөнд дархан Рааш охины хамт аж төрөн сууж байна. Гамин Барон үймсэн хэцүү цагт их хөлийн замаас нүүлгэхээр Онолт иржээ. Гэрэл хайрт Түмэнтэйгээ айлсах гэж баярлавч учир мэдэх Рааш өвгөн Онолттой уулзахаар гэрт орно. Энэ үед Онолтын хүү Түмэн шадар нөхдийн хамт ирж зэвсэг нуусан газар очихоор Гэрэлийг дагуулж явна. Зэр зэвсгээсээ хагацсан гамингууд хүн бүхнийг хардан сэрдэж Рааш, Онолт нарыг баривчилж “Мандан бадарч яваа бас нэг улсын голомт унтраг” гэж өрхийг нь бүтээнэ. Гэвч нутгийн ардууд өрхөө татаж “Галын дуу” өргөнө.

Хоёрдугаар үзэгдэл

Хиагт дахь гамин цэргийн хуаран. Го
силин тэргүүтэй цэргүүд Рааш, Онолт
нарт янз бүрийн арга хэрэглэж зэвсэг
нуусан газрыг хэлүүлэхийг оролдоно.
Идээ зоог барьж эзэн дээдэст өргүүлэхийг
тулгаж цэргийн сүр хүчээр далайлгаж, бас
цаазлан хороож буй хүнийг харуулна.
Эцэст нь хуурмагаар суллаж, араас нь
туршин тагнуулч тавина.

Гуравдугаар үзэгдэл

Түмэн шадар нөхөд болон гэрэлийн хамт зэвсэг нуусан агуйг хайж байна. Гэрэл аавтайгаа цуг нэг удаа энд ирсэн учир газраа олохгүй сандарчээ. Энэ үед эцэж туульдсан Рааш, Онолт нар гарч ирэн зэвсгээ авахыг зөвлөнө. Гэтэл тэднийг мөшгөн дагаж ирсэн гамингууд Раашийн амь насыг бүрэлгэн, Түмэнг баривчилж, түүний барьцаанд Сүхбаатарыг хөнөөлгөхөөр Онолтыг арга буюу зөвшөөрүүлэн явуулна.

Дөрөвдүгээр үзэгдэл

Монгол ардын журамт цэргийн хуаран.Шадар цэргүүд, Гэрэл нар нөхдөн хамт ирж тулаанд бэлтгэнэ.Энэ үед эргэлзэж төөрсөн Онолт ирж Гэрэлтэй уулзана.Бүхний учрыг олоход Сүхбаатар туслах тухай Гэрэлийг хэлэхэд Онолт түүнтэй уулзахыг гуйна.

Тавдугаар үзэгдэл

Хиагтыг дайрахийн өмнөхөн Го болон гамин цэргийн дарга нар баривчлагдсан. Түмэнгээс эцсийн өчиг авахаар тулган байцааж, арга ядахдаа цаазаар хороохоор шийдвэрлэнэ. Гэтэл ардын журамт цэргийн элч нар ирж тулган шаардсан бичиг гардуулна. Түүний хариуд элч нарыг баривчилна. ардын журамт цэрэг хиагтыг дайрлаа. Хар санаа нь бүтээгүй Го, Онолтыг буудаад зугтана. Ардын журамт цэрэг хиагтыг эзэллээ. Гэрэл, Түмэн нар уулзаж Сүхбаатар шинэ монголын ирээдүйг зааж захиана. Их ялалтын дараа амс хийх зуур ардын журамт цэрэг хувьсгалийн баатарлаг дуу “Шивээ хиагт”-ыг зохиож дуулна.



1926 оны зургадугаар сарын нэгэнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт, Зүүн хашаатын "Яндаг худаг" гэдэг газар төрсөн.

Хөгжмийн их сургуулийн найрал дууны удирдаачийн ангид суралцаж хөгжмийн зохиомж заалгасан юм. 1960-1963 онд Улсын хөгжимт драмын театрт найрал дууны багш, 1963-1975 онд Улсын дуурь бүжгийн театрын уран сайхны удирдагч, 1975 оноос Улсын ардын дуу бүжгийн чуулгад уран сайхны удирдагчаар ажиллажээ.

Д.Лувсаншарав
1926-2014

Энэ зохиол аль нь вэ?

- Дуу
- Бүжиг
- Бүжгэн жүжиг
- Найрал дуу
- Дуурь

Дуурийн ари гэж юу вэ?



Онолтын ари

- Утга санааг тодорхойлоорой.



Музыкальная запись песни «Онолтын ари» в нотной форме. Запись состоит из двух строк. Первая строка начинается с ноты «Б» (B-flat) и имеет метр «С» (Common time). Вторая строка начинается с ноты «Б» (B-flat) и имеет метр «4» (4/4). Под нотами приведены монгольские тексты. Два красных вопроса с стрелками указывают на конкретные ноты: первый вопрос указывает на ноту «Б» в начале первой строки, второй — на ноту «Б» в начале второй строки.

Бу-ян үйл-дэж өр-гөл бар-ъя бур-хан минь_ таа- лаж_хай-рла я-вах га - заргүй_ энэ_хор-воод

4
яа-хыг на-дад заажсоё-рох бур-хан чи_ бай- нуу_үгүй юу бур-хан гэ - дэг байх-гүй ю-муу



Шивээ Хиагт” дуурийн онцлог нь Ардын хувьсгалын анхны үйл явдлыг илэрхийлсэн хөгжмийн томоохон бүтээл төдийгүй, ард түмний чин зоригт хүү, жанжин Д.Сүхбаатарын дүрийг анх удаа дуурийн урлагийн тайзнаа гаргасан явдал юм.





Шивээ хиагт дуурь

Д.Сүхбаатар ард түмэндээ хандан шинэ Монголын ирээдүйн чигийг заасан алдарт гэрээслэл энэхүү дуурьд дуулагддаг. Гурван бүлэг таван үзэгдэлтэй.

Дуурийг яагаад хаан урлаг гэдэг вэ?

- 1. Дуулаачийн хамгийн том төрөл.*
- 2. Урлагийн бусад төрлүүдийн нэгдлээс бүтдэг нийлмэл урлаг.*
- 3. Тухайн үеийн нийгмийн амьдралыг тэр чигт нь харуулж чаддаг.*

Шивээ хиагт дуурийн Онолтын
ари нь Ардын уран зохиолч
Д.Пүрэвдоржийн цомог зохиолоор
Монгол улсын хөдөлмөрийн
баатар Ардын жүжигчин хөгжмийн
зохиолч Д. Лувсаншарав 1971 онд
“Шивээ хиагт” дууриа бичжээ.

Дуурийн гол дүр болох Онолтын ари нь өвгөний сэтгэлийн дотоод ертөнцийг нээн харуулахад зориулагдсан бөгөөд уг дуурийн хөгжмийн “нандин шигтгээ” болно. Шаналан зовсон Онолт өвгөний сэтгэлийн их зовиурыг илэрхийлсэн.

Дүгнэлт

1. Үг, аялгууны харилцан хамаарал, дуурийн дуучин хүн жүжигчин байх ёстойн учир юу вэ?
2. Онолтын сэтгэл санааны төлөв байдал, цөхрөл, гуниг зовлонг хэрхэн яаж илэрхийлсэнийг ноот бичлэгээс харан тайлбарлаарай.

Бу-ян үйл-дэж өр-гөл бар-ъя бур-хан минь_ таа- лаж_хай-рла я-вах га - заргүй_ энэ_хор-воод

4
яа-хыг на-дад зааж соё-рох бур-хан чи_ бай- нуу_үгүй юу бур-хан гэ - дэг байх-гүй ю-муу